



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИГ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 1143

Улаанбаатар хот.

Үнэ, тариф тогтоох тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10 дэх заалт, Зам, тээврийн сайдын 2015 оны 327 дугаар тушаал, Төрийн өмчийн хорооны 2015 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.9.9, 6.11 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улс, хот хооронд, жуулчин болон орон нутгийн тээвэрлэлтийн үйлчилгээнд ашиглах маягт, баримт бичгийн үнийн тарифыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан үнэ, тариф дээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан хувиар татвар тооцон ногдуулж, тайлан бүртгэлд тусган хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ш.Баяраа/-т үүрэг болгосугай.

3. Тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг олгох, тээвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдүүлэн, зохион байгуулж ажиллахыг Тээвэр зохицуулалтын газар /Ж.Энхбат/-т даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээвэр хариуцсан дэд захирал /Д.Батбаатар/-д үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын албаны захирлын "Тээвэрлэлтийн зарим баримт бичиг, маягтын үнэ шинэчлэн тогтоох тухай" 2012 оны 288 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ  Н.ГҮНЦАГ



009000183

Автотээврийн үндэсний төвийн захирлын
2016 оны 02 дугаар сарын 02-ны
өдрийн 11/10 тоот тушаалын хавсралт



Тээвэрлэлтийн баримт бичиг, маягтын үнэ тариф

№	Баримт бичгийн нэр	Хэмжих нэгж	Үнэ, тариф
1	Хот хоорондын болон хотын доторх ачаа тээврийн замын хуудас	ш	1000
2	Хотын доторх болон хот орчмын зорчигч тээврийн замын хуудас	ш	200
3	Зорчигч тээврийн замын хуудас (Хот хооронд)	ш	100
4	Орон нутгийн замын хуудас	ш	30
5	Ачааны дагалдах бичиг (Хот хооронд)	ш	1000
6	Ачааны дагалдах хуудас (ОХУ)	ш	1000
7	Ачааны дагалдах хуудас (Хятад)	ш	1000
8	Зорчигч тээврийн дагалдах хуудас (Хятад), (ОХУ)	ш	1000
9	Бүртгэлийн карт (Зорчигч тээвэрлэлт)	ш	2000
10	Таних тэмдэг (Зорчигч тээвэрлэлт)	ш	1000
11	Жуулчин TOURIST наалт (Жуулчин тээвэрлэлт)	ш	50000
12	Жолоочийн таних тэмдэг (Жуулчин тээвэрлэлт)	ш	1000
13	MGL наалт	ш	3000
14	Хот хоорондын зорчих тасалбар	ш	25
15	Орон нутгийн зорчих тасалбар	ш	25
16	Тооцооны хуудас	ш	30